

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2024/1

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.I	2023.I	2023.XII	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 4-р улирал	их наяд ₮, оны үнээр	68.8	52.8	46.5	-	-	-	7.0% ▲
Инфляц	хувь	7.6	12.3	7.9	0.8% ▲	-	0.8% ▲	-4.7 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	3.9% 2023 оны У4	5.3% 2022 оны У4	5.2% 2023 оны У3	-	-1.3% ▼ нэгж хувиар	-	-1.4% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	676	-31.6	763	-87 ▼	-	-	707 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3407.37	3467.21	3421.21	-13.84 ▼	-	-	-59.84 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	388.9	389.7	5932	-	-	-	-0.8 ▼
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	6.6	3.6	66.7	-	-	-	2.97 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	124.1	110.7	1524.8	-	-	-	13.45% ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	13%	13%	0%	-	0%	0%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.84	3.56	4.91	-1.47% ▼	-	-	36.2% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	7.38%	9.01%	7.45%	-0.06 нэгж хувиар ▼	-	-	-1.62 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

Монгол Улсын эдийн засаг 2023 онд 7%-р өсөв	ДНБ 2023 онд 7.0 хувиар өссөний -1.3 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар, 2.6 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 0.6 нэгж хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 4.3 нэгж хувийг үйлчилгээний салбар, 0.9 нэгж хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар бүрдүүлсэн байна.
Төгрөгийн ханш чангарсаар	Төгрөгийн ханш сүүлийн 5 сар дараалан чангарсаар байна. Энэ нь гадаад худалдаа болон урсгал тэнцлүүд ашигтай гарсан мөн нүүрсний экспорт сайн хийгдэж буйтай холбоотой.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Малчдын зээлийг хойшлуулав	2/20/2024	Монгол банкны мэдээллийн санд 140 мянга гаруй малчдын 1.2 их наяд төгрөгийн зээл бүртгэлтэй байна. Хаан банкны хувьд өнгөрсөн оны 12 дугаар сарын 1-нээс хойш хүсэлт өгсөн малчдын зээлийн эргэн төлөлтийг сунгаж буй аж. Төрийн банкны хувьд эхний ээлжинд энэ оны 6 дугаар сарын 1 хүртэл зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах боломжтойг мэдээлсэн юм.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Нөлөөлөл

Инфляц




Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 1 дүгээр сард 12.3 хувь гарсан бол 2024 оны 1 дүгээр сард 7.6 хувь болж, өсөлтийн хурдац өмнөх оны мөн үеэс 4.7 нэгж хувиар буурсан байна. Улсын инфляцад бензин, түлшнээс бусад импортын барааны үнэ 2.6 нэгж хувиар (34.2%), мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнэ 3.6 нэгж хувиар (47.4%) тус тус нөлөөлсөн байна. Харин Улаанбаатар хотын инфляц 8.2 хувь байна.

Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 1 дүгээр сард 3407.37 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 59.84 төгрөгөөр, өмнөх сараас 13.84 төгрөгөөр тус тус суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас -1.47% буурч, өнгөрсөн жилийн мөн үеэс 36.2%-иар өсөж, 4.84 тэрбум ам.долларт хүрэв.

Улсын төсөв



Татварын нийт орлого 2024 оны 1 дүгээр сард 2.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.6 (2.6 дахин) их наяд төгрөгөөр өсөхөд орлогын албан татварын орлого 544.2 (3.4 дахин) тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 668.9 (41.1 дахин) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 147.0 (48.8%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 64.1 (2.2 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Орлогын албан татварын 78.0 хувийг ААНОАТ, 22.0 хувь (буцаан олголтыг хассан дүнгээр)-ийг ХХОАТ-ын орлого бүрдүүлж байна.

Гадаад худалдаа



Монгол Улс 2024 оны 1 дүгээр сард нийт 115 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 2.3 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 1.3 тэрбум ам.доллар, импорт 936.0 сая ам.долларт хүрч, тэнцэл 388.9 сая ам.долларын ашигтай гарсан байна. Экспорт 2024 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 244.8 сая ам.доллаар өсөхөд нүүрс 240.5 сая ам.доллар, зэсийн хүдэр, баяжмал 36.6 сая ам.доллар, төмрийн хүдэр, баяжмал 21.3 сая ам.доллаар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 1-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 1-р сар 2024 он, Монголбанк](#)
3. www.1212.mn, www.mongolbank.mn